



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.19 № 318

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн НАЦАГДОРЖИЙН ӨСӨХБАЯР-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн НАЦАГДОРЖИЙН ӨСӨХБАЯР-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-

аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн НАЦАГДОРЖИЙН ӨСӨХБАЯР-ын орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Нацагдоржийн Өсөхбаярын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Нацагдоржийн Өсөхбаярт

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР/



192

**ДАРХАН-УУЛ АИМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024
ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ НАЦАГДОРЖИЙН
ЭСӨХБАЯРЫН “ИРГЭН БҮРД ЭЭЛТЭЙ-ДАРХАН” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

“ИРГЭН БҮРД ЭЭЛТЭЙ-ДАРХАН”

Зорилго: Дарханчууд бид ажилсаг хичээнгүй, оюуны өндөр чадамжтай алсын хараатай, аливаад ул суурьтай ханддаг ард түмэн билээ. Газарзүйн чухал байршил, уур амьсгалын тааламжтай орчин, хүн амын төвлөрөл харьцангуй бага тул аз жаргалтай, баян тансаг, амар тайван, эрүүл саруул амьдрах бүрэн боломжтой.

Ард түмэн бид бүхэн төрдөө итгэх итгэлээ сэргээхийн тулд тогтвортойгоор засаглаж чадах, эвлэлдэн нэгдэх чадвартай, ямар нэгэн бүлэг фракцад хуваагдаж эрх ашигт барьцаалагдаагүй, иргэдийнхээ зовлон жаргалыг мэддэг Дархан-Уул аймагтаа ажиллаж амьдардаг тэднийхээ төлөө ажиллах чин хүсэл эрмэлзэлтэй улс төрчийг хүлээж байна.

Тиймээс миний бие аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулиар та бүхнийхээ дэмжлэгийг хүсч, Дархан нутгийн ирээдүй хойч үеийнхээ эрх ашгийн төлөө хэрэгжүүлэх бодлогоо тусгасан **“ИРГЭН БҮРД ЭЭЛТЭЙ-ДАРХАН”** мөрийн хөтөлбөрөө хүргэж байна.

1. ЭРҮҮЛ МЭНД

1.1 Аймаг, сум багийг холбосон алсын зайн оношлогоо, эмчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээний сүлжээ бий болгоно.

1.2 Малчид, тариаланчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, явуулын эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол болгоно.

1.3 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлэн гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна.

2. БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН САЛБАР

2.1 Хүүхдийн “Хөдөлмөр” зусланг сэргээн хөгжүүлж, амьдрах ухаан, уламжлалт ахуйд суралцуулна.

2.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үе тэнгийнхнийх нь дунд сурч боловсрох нөхцлийг бүрдүүлнэ.

2.3 Их дээд сургууль төгссөн залуучуудыг төрийн албанд намын харъяалалгүй ажиллуулах боломжийг бүрдүүлж, сум орон нутагт хэрэгцээтэй байгаа мэргэжлээр боловсон хүчин бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх бололцоог бий болгоно.

2.4 Суманд ажиллахаар очсон багш, эмч зэрэг мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллах бололцоог бүрдүүлж, байраар хангах, бага хүүтэй хөнгөлөлттэй зээлэнд хамруулах хөтөлбөрийг боловсруулна.

2.5 Халамжийн хавтгайрсан бодлогыг өөрчилж, нийгмийн халамжийг зохих эзэнд нь хүрдэг болгоно.

3. “ЧИНЭЭЛЭГ ДУНДАЖ ДАВХАРГА” БҮРДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАНА

3.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг шинэчлэх замаар өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжинэ.

3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд саадгүй оролцох боломж бүрдүүлж, тэднийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгоно.

3.3 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийг жинхэнэ эзэддээ очдог болгоно. Иргэн бүр ажилтай орлоготой байх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.4 Шинээр байгуулагдсан болон боловсон хүчний хувьд бүрэн бэхжээгүй компани, хоршоо, нөхөрлөлийг Дархан-Уул аймагт орон нутгийн болон улсын төсвөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудад туслан гүйцэтгэгчээр ажиллуулан ажлын туршлагатай болгох, шударга өрсөлдөөн бий болгох бодлого баримтална.

4. ТӨРИЙН АЛБАНД ШУДАРГА ЁСЫГ ТОГТООНО

4.1 Сонгуульд ялалт байгуулсан намууд мэргэшсэн төрийн албан хаагчдыг олноор нь хоморголон ажлаас халдаг байдлыг таслан зогсооно.

4.2 Дархан-Уул аймагт төрийн албанд ах, дүү, хамаатан, садан, танилаа оруулж, ажил цалгардуулдаг байдлыг болиулж, хуульд заасан төрийн албаны мерит тогтолцоог барьж ажиллана.

4.3 Хууль гажуудуулж, хуулийг уландаа гишгэсэн төрийн түшээдээс хариуцлага нэхэхийг шаардаж ажиллана.

4.4 Аливаа төсөл, тендерийн шалгаруулалт, концесс, бараа ажил үйлчилгээ худалдан авах шалгаруулалт, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд очих зээлийн журмыг шинээр боловсруулан батлуулж, хяналт тавьж ажиллана.

4.5 Иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, төрийн албаны хүнд суртлыг бүрэн арилгана.

4.6 Дархан-Уул аймагт гарч байгаа хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, гомдлыг шуурхай шалгаж шийдвэрлэдэг болно.

5. МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН

5.1 Тариалан эрхлэгчид, зөгийчдийг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээл, тариалан эрхлэлтийг дэмжих сангийн зээлүүдэд хамрагдахад аймаг орон нутгаас дэмжиж ажиллана.

5.2 Хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг байгалийн давагдашгүй хүчин зүйлээс сэргийлэх үүднээс холбогдох байгууллагуудад санал тавьж, даатгалд хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

5.3 Эрчимжсэн мал аж ахуй болон фермерийн аж ахуйг хөгжүүлж буй малчдад хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгох, малчинд ээлтэй хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.4 Хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг шинэ шатанд гаргана.



НЭР ДЭВШИГЧ: *Н. Оюундэв*

Н.ӨСӨХБАЯР